**“УСЖУУЛАХ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2023 оны ...дүгээр сарын ... ний өдөр

№ \_\_

Увс аймаг Баруунтуруун сум

*Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, “Усжуулах” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3.1 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ..... тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Компанийн дүрмийн 7-р бүлэг 7.9 дэх заалтад дараах байдлаар өөрчлөлт оруулсугай.
  - ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 8 (Найм) жил байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хувьцаа эзэмшигч биш байж болно. Харин ТУЗ-ийн дарга нь компанийн хувьцаа эзэмшигч байна.
2. Компанийн дүрмийн 14-р бүлэгт тусгасан заалтыг агуулгаар нь дараах байдлаар дугаарлан нэмэлт өөрчлөлт оруулсугай.
  - 14.1 Энэхүү дүрмийг 4 хувь Монгол хэлээр үйлдэн компанийн тэмдэг дарж, бүртгэх байгууллага, ТУЗ, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тус бүр нэгийг хадгалуулна. Дүрмийн эх хувиудын хооронд зөрүүтэй зүйл гарвал компанийн нарийн бичгийн дарга эсхүл бүртгэх байгууллагад хадгалагдаж буй хувийг эх болгоно.
  - 14.2 Дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсэнээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.
  - 14.3 Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг “Компанийн тухай хууль” болон энэхүү дүрэмд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь бүртгэх байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох бичиг баримтыг хүргэх, дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Ундрах/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Нямбаяр/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.ЭРХЭМБАЯР

## “УСЖУУЛАХ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компаний үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Компани нь хувьцаагаа нийтэд санал болгон гаргасан нээлттэй, хувьцаат компани мөн.
- 1.3 Компанийн оноосон нэр: Монголоор “УСЖУУЛАХ” ХК Хаяг нь: Увс аймаг Баруунтуруун сум “Усжуулах” ХК-ийн байр
- 1.4 Компани нь хуулийн этгээддийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.5 Компани нь ТУЗ-ийн шийдвэрээр салбар, төлөөлөгчийн газар, охин болон хараат компани байгуулж болно.
- 1.6 Компани нь өөрийн албан бичгийн хуудас, тамга, тэмдэгтэй байна.
- 1.7 Компани нь өөрийн бэлэгдэл, барааны тэмдэгтэй бай бөгөөд түүний загварыг ТУЗ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлэн тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн Усжуулах ХК эдэлнэ.

### Хоёр. Компанийн үйл ажиллагааны чиглэл

- 2.1 Компани нь дор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ.
  - 2.1.1 Үр тариа болон бусад ургамал тариалалт
  - 2.1.2 Таван хошуу мал, сүүний фермийн үйл ажиллагаа
- 2.2 Үндсэн үйл ажиллагаатай уялдаагүй бусад бусад үйл ажиллагаа эрхлэх асуудлыг зөвхөн ТУЗ шийдвэрлэнэ.
- 2.3 Компанийн удирдлага, үйл ажиллагааны үндсэн баримт бичиг нь компанийн дүрэм мөн бөгөөд дүрмээр зохицуулагдаагүй аливаа асуудлыг компанийн тухай болон бусад хуулийн заалтыг үндэслэл болгон шийдвэрлэнэ.

### Гурав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө ба хувь нийлүүлэгч

- 3.1 Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаж, үлдсэн хэсэг нь компанийн өөрийн хөрөнгө байна.
- 3.2 Компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэнэ.
- 3.3 Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 489,262 /дөрвөн зуун наян есөн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг буюу нийт 48,926,200 /дөчин найман сая есөн зуун хорин зургаан мянга хоёр зуун/ төгрөгийн үнэтэй хувьцаануудаас бүрдэнэ.
- 3.4 Хувьцааг нэрлэсэн үнээс бага үнээр гаргахыг хориглоно.
- 3.5 Энгийн хувьцаа нь хуваагдахгүй бөгөөд хувьцаа тус бүр нь нэг саналын эрхтэй байна.

3.6 Хувьцаа нэмж гаргасан тохиолдолд компанийн хувь нийлүүлэгчид тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй бөгөөд энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 39-р зүйлд заасны дагуу хэрэгжүүлэх эрхийг ТУЗ хүлээнэ.

#### Дөрөв.Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага

- 4.1 Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 4.2 Компанийн гаргасан энгийн хувьцаанаас худалдан авч эзэмшсэн этгээдийг компанийн хувьцаа эзэмшигч гэнэ.
- 4.3 Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- 4.4 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

#### Тав. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

- 5.1 Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч тогтоосон хугацаанд олгоогүй тохиолдолд алданги төлөхийг шаардах эрхтэй.
- 5.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийг худалдсанаас олох орлогоос өр төлбөрийг хасаж, үлдэх хэсгээс өөрийн эзэмшдэг хувьтай хувь тэнцүүлэн хүртэх эрхтэй.
- 5.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
- 5.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцаа эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй.
  - 5.5.1 Компанийг нийлүүлэх,нэгдэх, хуваах замаар өөрчлөх, компанийн хэлбэрийг ХХК болгон өөрчлөх
  - 5.5.2 Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан
  - 5.5.3 Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхол бүхий этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмших болсон үед бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй.

#### Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 6.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 6.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг жил бүрийн 05 сарын 01-ний дотор ТУЗ-өөс зарлан хуралдуулна.
- 6.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
  - 6.3.1 Компаний дүрэм батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах

- 6.3.2 Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буулгах комиссыг томилох
  - 6.3.3 Хувьцааг хуваах буюу нэгтгэх, өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох
  - 6.3.4 ТУЗ-ийн гишүүнийг сонгох, түүний эрх хэмжээ, хариуцлага, тайланг хэлэлцэх, ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
  - 6.3.5 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх
  - 6.3.6 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
  - 6.3.7 Компани өөрий хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх
  - 6.3.8 ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх
- 6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь саналын эрхтэй нийт хувьцааны 50-иас дээш хувийн эзэмшиж буй хувьцаа эзэмшигч буюу эдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцсоноор хүчин төгөлдөр болно. Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцно.
- 6.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заана.
- 6.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн бүх асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд хурлын дарга гарын үсэг зурна. Хурлын ирц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэл, тогтоолуудыг компанийн бүртгэлд бүртгэж хадгална.
- 6.7 Ээлжит бус хурлыг ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч эсхүл ТУЗ “Компанийн тухай хууль”-д заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.
- 6.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг тухайн хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцэж болно.
- 6.9 Хувьцаа эзэмшигч нь хурлаас гарах шийдвэрт өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгч болно. Итгэмжлэл нь Монгол Улсын “Иргэний хууль”-д заасны дагуу бичгээр үйлдэгдэж, нотариатаар гэрчлэгдсэн, итгэмжлэгч, итгэмжлэгдэгчийн овог нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, итгэмжлэлээр олгож байгаа эрх буюу итгэмжлэлээр төлөөлж санал өгөх хувьцааны тоо, итгэмжлэлийн хүчинтэй байх хугацаа зэргийг заавал тусгасан байна.
- 6.10 Итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшлогдсон боловч хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй бол итгэмжлэл нь хойшлогдсон хуралд хүчинтэй байна.
- 6.11 Энэхүү дүрмийн 6.4-р зүйлд заасан ирц бүрдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулж дахин хуралдуулах өдрийг товлоно. Хойшлогдсон хурлаар хэлэлцэхээр товлосон асуудлыг өөрчилж үл болно.
- 6.12 Саналын эрхийн гуравны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 6.13 “Компанийн тухай хууль”-ийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 6.14 Хойшлогдсон хурлын ирц 6.12, 6.13-т заасан хувь хэмжээнд хүрээгүй тохиолдолд хурлыг хүчингүй гэж үзэж дахин шинээр хурал зарлах бөгөөд энэхүү хурал нь 6.4-т заасан хувиар хүчин төгөлдөр болно.

- 6.15 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь хуулинд илүү өндөр тогтоогоогүй бол хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.
- 6.16 Хуулиар хориглоогүй бол асуудлыг эчнээ санал хураалтаар шийдэж болно.
- 6.17 Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр ажиллах тооллогын комиссыг тухайн хурлыг хуралдуулах шийдвэр гаргасан этгээд томилох бөгөөд тооллогын комисс нь “Компанийн тухай хууль”-д заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 6.18 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг санал авах хуудсыг ашиглан явуулна. Эчнээ санал хураалтанд нийт хувьцаа эзэмшигчдийн 50-иас дээш хувь нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд санал хураалтанд оролцогсдын олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

#### Долоо. Төлөөлөн Удирдах Зөвлөл

- 7.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ байна. ТУЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.
- 7.2 ТУЗ нь /9/ гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.
- 7.3 ТУЗ нь “Компанийн тухай хууль” болон энэхүү дүрмээ хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсанаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
  - 7.3.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох
  - 7.3.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлит бус хурлыг зарлан хуралдуулах
  - 7.3.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жасаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх
  - 7.3.4 ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээг тогтоох
  - 7.3.5 Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах
  - 7.3.6 Энэхүү дүрмэнд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах
  - 7.3.7 Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох
  - 7.3.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалт чвуулах замаар шийдвэрлэх тухай шийдвэр гаргах
  - 7.3.9 Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, чиглэл өгөх
  - 7.3.10 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээ, хариуцлагыг тогтоох
  - 7.3.11 Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох
  - 7.3.12 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах
  - 7.3.13 Ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох
  - 7.3.14 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг тодорхойлох
  - 7.3.15 Компанийн удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтэц, захиргааны зардлын хэмжээг тогтоох
  - 7.3.16 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах
  - 7.3.17 Компанийг өөрчлөн байгуулах талаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх

- 7.3.18 Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг олгох: Их хэмжээний хэлцлийг ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтгэйгээр шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиодолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.3.19 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох
- 7.3.20 Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг төлөөлөн удирдах зөвлөл нөхөн сонгууль явуулах хүртэл түр томилж болно.
- 7.3.21 Хөрөнгө оруулалтын хэмжээг шийдвэрлэх, батлах
- 7.3.22 Гүйцэтгэх захирлаас шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд болон хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-өөр шийдвэрлүүлэхээр тогтоосон бусад асуудлууд
- 7.4 ТУЗ-ийн гишүүнийг санал хураах кумулятив аргаар сонгоно. Энэ аргыг хэрэглэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журмыг баримтална.
- 7.5 Компанийн нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд “Компанийн тухай хууль”-ийн 79.1-д заасан шалгуурыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ.
- 7.6 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх үүрэгтэй байхаас гадна “Компанийн тухай хууль”-ийн 79.3-т заасан нэмэлт үүргийг хүлээнэ.
- 7.7 Энэхүү дүрмийн 7.3.7, 7.3.11, 7.3.19-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө.
- 7.8 ТУЗ анхны хурлаараа өөрийн гишүүдийн дотроос ТУЗ-ийн даргыг нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 7.9 ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 8 жил байх бөгөөд ТУЗ-ийн гишүүн нь хувьцаа эзэмшигч биш байж болно. Харин ТУЗ-ийн дарга нь компанийн хувьцаа эзэмшигч байна.
- 7.10 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хийх бөгөөд хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, гүйцэтгэх удирдлага зарлан хуралдуулна. ТУЗ-ийн гишүүдэд хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.
- 7.11 Нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурсанар хүчин төгөлдөр болно.
- 7.12 ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.13 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.

#### Найм. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

- 8.1 ТУЗ нь нарийн бичгийн даргатай байх ба ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 8.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дараахь үүрэгтэй. Үүнд:
  - 8.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,
  - 8.2.2 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах
  - 8.2.3 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжидтэнд хяналт тавих

- 8.2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах,
  - 8.2.5 ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах
  - 8.2.6 Компанийн нарийн бичгийн дарга нь энэ дүрмийн 8.3-т заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.
- 8.3 Компанийн нарийн бичгийн дарга дараахь бүртгэлийг хөтөлж, холбогдох баримт бичгийг хадгална.
- 8.3.1 Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
  - 8.3.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг
  - 8.3.3 Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт
  - 8.3.4 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын шийдвэр, тэмдэглэл
  - 8.3.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан санхүүгийн тайлан
  - 8.3.6 Хувьцаа болон үнэт цаас гаргах журам
  - 8.3.7 Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тоо хэмжээ
  - 8.3.8 “Компанийн тухай хууль”-д заасан бусад бичиг баримт
- 8.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах бүртгэлийг хөтөлж холбогдох баримт бичгийг хадгална.
- 8.4.1 Хувьцаа эзэмшигч тус бүрийн овог нэр, эзэмшиж буй хувьцааны тоо, тэдгээрийн нийт үнийн дүн, олгосон ногдол ашиг
  - 8.4.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг товлосон он, сар, өдөр, газар, цаг болон хурлын дарга, нарийн бичгийн даргын овог нэр, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо, хурлаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр, тогтоол тус бүрт хувьцаа эзэмшигчдийн өгсөн санал
- 8.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн бичиг баримтыг дараах журмын дагуу хадгална.
- 8.5.1 Энэ дүрмийн 8.3-т заасан баримтыг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газар буюу хувьцаа эзэмшигчдийн мэдэх, тэдний нэвтрэх боломж бүхий газар хадгалах
  - 8.5.2 Дүрэм, түүний нэмэлт өөрчлөлтийг байнга хадгалах. Энэ дүрмийн 8.3-т заасан бусад бичиг баримтыг нарийн бичгийн дарга нь 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа эдгээр бичиг баримтыг архивт шилжүүлэх

#### Ес.ТУЗ-ийн дэргэдэх хороо

- 9.1 ТУЗ нь тодорхой асуудал эрхэлсэн аудитыг, цалин урамшуулын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 9.2 Хорооны гишүүнийг ТУЗ-ийн дарга томилж, чөлөөлнө.
- 9.3 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна. Үүнд:
  - 9.3.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих



- 9.3.2 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах
- 9.3.3 Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах
- 9.3.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
- 9.3.5 Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал
- 9.4 Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ Үүнд:
  - 9.4.1 ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох
  - 9.4.2 ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд “Компанийн тухай хууль”-ийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх
  - 9.4.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх
  - 9.4.4 ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх
  - 9.4.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах
  - 9.4.6 ТУЗ-ийн гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах
  - 9.4.7 “Компанийн тухай хууль”-ийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсоноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах
- 9.5 Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.
  - 9.5.1 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих
  - 9.5.2 ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах
  - 9.5.3 Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж үр дүнг үнэлэх

#### Арав. Гүйцэтгэх удирдлага

- 10.1 Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 10.2 Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хууль тогтоомж, компанийн дүрэмд болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.
- 10.3 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх хэмжээг түүнтэй байгуулсан гэрээнд тодорхой тусгах бөгөөд Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 10.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, ТУЗ-ийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хангуулах
  - 10.3.2 ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох

- 10.3.3 Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх
  - 10.3.4 Өөрт олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах
  - 10.3.5 Компанийн үйл ажиллагааг зохион байгуулан явуулж өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангах
  - 10.3.6 Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах
  - 10.3.7 Компанийн албадыг нэгдсэн удирдлагар хангах, компанийн бүтэц, зохион байгуулалтын нэгжийг байгуулан ажиллуулах
  - 10.3.8 Компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээлгэх асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч хариуцагчаар оролцох
  - 10.3.9 Компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан бусад эрх
- 10.4 Гүйцэтгэх захирал нь өөрийн эрх үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр 21 хоногоос дээшгүй хугацаагаар холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

#### Арван нэг. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага

- 11.1 ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, дэд захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, салбарын эрхлэгч болон эдгээртэй адилтгах албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 11.2 Эрх бүхий албан тушаалтан нь “Компанийн тухай хууль”, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар ажиллах үүрэгтэй.
- 11.3 Эрх бүхий албан тушаалтан нь дараах хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас компани хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.
  - 11.3.1 Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан
  - 11.3.2 Хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид санаатайгаар хуурамч мэдээлэл өгсөн
  - 11.3.3 Мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй
  - 11.3.4 Компанийн бичиг баримтыг энэ дүрэм болон бусад дүрэм журамд заасны дагуу хадгалаагүй, зөвшөөрөлгүйгээр гадны этгээдэд дамжуулсан, нууцын зэрэглэлийг алдагдуулсан зэрэг зөрчил гаргасан
  - 11.3.5 Компанийн дүрэм ТУЗ-аас баталсан дотоод журмыг ноцтой зөрчсөн компанийн нууц мэдээг гуравдагч этгээдэд дамжуулсан, эсвэл хувийн зорилгоор ашигласан
  - 11.3.6 ТУЗ болон компанитай байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээ компанийн дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулсан эрх хэмжээг хэтрүүлсэн
  - 11.3.7 Компанийн тухай хуулийн 98-р зүйлд заасан мэдээллийг мэдээлэл авах эрх бүхий этгээдэд гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулан гаргаж өгсөн

#### Арван хоёр. Компанийн Аудиторын хяналт

- 12.1 Аудитын тухай МУ-ын хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн

шалгалт хийлгэх зорилгоор ТУЗ нь эрх бүхий аудитын байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулан ажиллана.

- 12.2 ТУЗ-ийн аудитын хороо аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батлах бөгөөд Гэрээнд аудиторын эрх үүрэг хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 12.3 Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
- 12.4 Ээлжит бус шалгалтыг ТУЗ түүний аудитын хороо, эсвэл энгийн хувьцааны 10-аас дээш хувийн эзэмшигчийн шаардсанаар болон Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдийд ч хийж болно. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн Хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсвэл Хувьцаа эзэмшигч компани хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- 12.5 Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй албан тушаалтны буруугаас аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай этгээдээр төлүүлэх шийдвэрийг ТУЗ гаргана.
- 12.6 Дараах этгээдийг компанийн аудиторор сонгон ажиллуулахыг хориглоно.
  - 12.6.1 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой, компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан
  - 12.6.2 Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу хөрөнгийн эрх эзэмшдэг бол
- 12.7 Компанийн аудитор нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн “Компанийн тухай хуулийн 94.16-д зөвхөн мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана.

Арван гурав. Компанийн санхүү, бүртгэл, тайлан, ногдол ашгийн хуваарилалт

- 13.1 Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 01-нээс эхэлж, 12 сарын 31-нд дуусгавар болно.
- 13.2 Санхүүгийн тайланд баланс, орлого, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үр дүнгийн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал болон нэмэлт тайлбарыг тусгана.
- 13.3 ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа тус бүрт хуваарилан олгох ногдол ашгийн хэмжээг тогтооно. Ногдол ашиг хуваарилан олгох, эсэх асуудлыг ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг хуваарилан олгох ажлыг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 13.4 Компани ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.
- 13.5 Дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна. Үүнд:
  - 13.5.1 Ногдол ашиг төлсөний дараа компани төлбөрийн чадвартай байх
  - 13.5.2 Ногдол ашиг төлсөний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрмийн 4.3 дахь хэсэгт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргээс их байх, эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх, доор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байж болно. Үүнд:

- Хуваарилагдах ашиг үлдээгүй
- Компанийн үйл ажиллагааг цаашид өргөтгөх хэвийн явуулах үүднээс ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ-өөс оруулсан саналыг хуралд оролцогчдын олонхийн саналаар зөвшөөрсөн

#### Арван дөрөв. Бусад

- 14.1 Энэхүү дүрмийг 4 хувь Монгол хэлээр үйлдэн компанийн тэмдэг дарж, бүртгэх байгууллага, ТУЗ, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тус бүр нэгийг хадгалуулна. Дүрмийн эх хувиудын хооронд зөрүүтэй зүйл гарвал компанийн нарийн бичгийн дарга эсхүл бүртгэх байгууллагад хадгалагдаж буй хувийг эх болгоно.
- 14.2 Дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсэнээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.
- 14.3 Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг “Компанийн тухай хууль” болон энэхүү дүрэмд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь бүртгэх байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.